UB


ДААТГАЛ

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН-2024

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Улаанбаатар хотын даатгал” ХХК нь 2024 онд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж, цахим шилжилт хийн, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг автоматжуулан цахим платформуудыг нэвтрүүлснээр борлуулалтын орлого өсч, салбар, төлөөлөгчийн газар, орон тоо нэмэгдэн компанийн үйл ажиллагаа өргөжин тэлсэн.

Улмаар 2024 оны 04 сарын 01-нд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан компанийн бүтэц, зохион байгуулалтад дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:



2024 онд “Улаанбаатар хотын даатгал” ХХК нь чиг үүрэг бүхий 7 газар, Дархан, Эрдэнэт, Багануур, Өмнөговь аймгийн нийт 4 салбар болон Улаанбаатар хотын 8 төлөөлөгчийн газар, нийт 42 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулан мэргэшсэн, дижитал даатгалын үр ашгийг хүн бүрт хүргэх зорилгийн дагуу Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, Автотээврийн хэрэгслийн даатгал, Орон сууцны иж бүрэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг голчлон үзүүлсэн байна.

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийн дагуу, СЗХ-ны даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 208 дугаар тушаалаар ТУЗ-ийн гишүүнээр Б.Золбаяр, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Д.Байлыхүү нарыг томилохыг зөвшөөрснөөр Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэйгээр бүрэн сонгогдсон.

ТУЗ-ийн гишүүд:

ТУЗ	Ердийн гишүүд			Хараат бус гишүүд	
					
Нэр	Ц.Чойбат	М.Энхболд	Б.Золбаяр	Д.Байлыхүү	Б.Батмөнх
Мэргэжил	Эдийн засагч	Эдийн засагч, Бизнесийн удирдлагын мастер	Бизнесийн удирдлага, эдийн засгийн мастер	Холбооны инженер, эдийн засагч	Программ хангамж, Компьютерын ухааны магистр,
Ажлын туршлага	Танан Импекс компанийг үүсгэн байгуулан 2002 оноос одоог хүртэл ажиллаж байна.	Банк, санхүүгийн салбарт 23 дахь жилдээ ажиллаж байна.	Даатгалын салбарт 16 дахь жилдээ ажиллаж байна.	ХХҮЭШЗТИ 1982-1990 ЗГӨХК 1990-1996 ТӨХ 1996-2012	ИНЕГ 2014-2015 ҮБХИС 2015-2018 Хас банк 2018 МХБ ТӨХК 2019 оноос одоог хүртэл
Хувьцаа эзэмшил	0%	34.3%	0%	0%	0%
Хурлын ирц, оролцоо	100%	100%	100%	100%	100%

Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийн дагуу, СЗХ-ны даргын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 432 дугаар тушаалаар эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрснөөр ТУЗ-ийн даргаар Ц.Чойбат, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Т.Халиунаа нарыг тус тус томилсон.

	Нэр	Албан тушаал	Хурлын ирц, оролцоо
	Ц.Чойбат	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	100%
	Т.Халиунаа	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	100%

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 1-3/07 тоот хурлын тогтоолоор ТУЗ-ийн дэргэд Аудит, эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог тус тус байгуулан гишүүдийг сонгон, хороодын үйл ажиллагааны журмыг баталсан.

Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдэд компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, батлагдсан хороодын журамд зааснаар ажиллахыг үүрэг болгосон.

ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн:

- Хорооны дарга: Б.Батмөнх
- Хорооны гишүүд: Д.Байлыхүү, М.Энхболд

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн:

- Хорооны дарга: Б.Золбаяр
- Хорооны гишүүд: Д.Байлыхүү, М.Энхболд

ТУЗ-ийн хурал

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 онд ээлжит болон ээлжит бус хурлыг 5 удаа зохион байгуулж, эчнээ санал хураалт 1 удаа явуулсан. ТУЗ-ийн хурал нь “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн төв салбарын хурлын танхимд зохион байгуулагдсан ба товолсон байрлалд өөрчлөлт ороогүй болно.

2024 онд Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 хурал 1 эчнээ санал хураалтаар нийт 14 асуудлаар 11 тогтоол баталж, хэрэгжилтийг хангасан байна. Үүнд:

- ТУЗ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилох
- 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, гэрээг батлах
- Даатгалын бүтээгдэхүүн батлах
- Өмнөговь салбарын хаяг өөрчлөх
- ТУЗ-ийн дарга томилох
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг батлах
- Компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, бизнес төлөвлөгөө, орон тоог батлах
- Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааг эрхлэх
- Комплайнс хариуцсан ажилтныг томилох
- 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах

ТУЗ-ийн хурлаар батлагдсан хавсралтууд

№	Огноо	Хурлууд	Хавсралт
1.	2024/01/29	ТУЗ-ийн ээлжит хурал	- 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө - Аудитын гэрээ
2.	2024/06/10	ТУЗ-ийн ээлжит хурал	- “Итгэл” эмчийн даатгалын нөхцөл, гэрээ байгуулах журам - “Итгэл” эмчийн даатгалын гэрээ
3.	2024/10/25	ТУЗ-ийн ээлжит хурал	- Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны журам - Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журам - Компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл - 2024 оны бизнес төлөвлөгөө, төсөв - Компанийн орон тоо
4.	2024/12/17	ТУЗ-ийн ээлжит санал хураалт	- 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

ТУЗ-ийн гишүүдийн сургалт

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чиглүүлэх, мэргэшүүлэх зорилгоор 2024 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд танхимын болон цахим нийт 5 сургалтыг зохион байгуулж, ТУЗ-ийн гишүүдийг хамруулсан болно. Үүнд:

№	Огноо	Сургалтууд	Хариуцсан ажилтан	Сургалтад хамрагдсан
1.	2024/05/21	Даатгалын салбарын хууль эрх зүйн орчин	Хууль, эрх зүй цахим нөхөн төлбөрийн мэргэжилтэн Д.Дэмчигсүрэн	ТУЗ-ийн шинэ гишүүд
2.	2024/06/07	Leedership exceeded Манлайллын сургалт	“Коуч Лаб” ХХК Мастер трайнэр, Бизнес көүч Э.Чинзориг	ТУЗ-ийн гишүүд болон нийт ажилтнууд
3.	2024/09/10	Компанийн засаглалын кодексын хүрээнд хэрэгжүүлж буй дүрэм, журам бодлогын баримт бичиг	Захиргаа, сургалт хариуцсан захирал Т.Халиунаа	ТУЗ-ийн хараат бус гишүү Д.Байлыхүү, ТУЗ-ийн гишүүн Б.Золбаяр
4.	2024/10/08	“Итгэл” эмчийн даатгалын бүтээгдэхүүний танилцуулга	Эрсдэлийн удирдлагын захирал О.Дүдарий	ТУЗ-ийн гишүүд болон нийт ажилтнууд
5.	2024/11/30	Төслийн удирдлагын мэргэшүүлэх сургалт	System center	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Батмөнх